Дуут сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгөөр сонгож,

материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 5211.1 сая төгрөгөөс 2 хувиар тооцон 104.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 83.3 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дуут сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 435.1 сая төгрөгөөр буюу 7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө, өмчийн данснууд байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлан /мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	87,607.3	122,685.8	-35,078.50	140%
Авлага	229,373.1	201,735.1	27,638.00	88%
Бараа материал	66,853.9	68,876.4	-2,022.50	103%
Үндсэн хөрөнгө	5,654,305.7	5,211,140.0	443,165.70	92%
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,038,140.0</b>	<b>5,604,437.3</b>	<b>433,702.70</b>	<b>93%</b>
Богино хугацаат өр төлбөр	11,207.0	4,317.5	6,889.50	39%
Цэвэр хөрөнгө, өмч	6,026,933.1	5,604,714.9	422,218.20	93%
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,038,140.1</b>	<b>5,609,032.4</b>	<b>435.107.7</b>	<b>93%</b>

Эх сурвалж: Дуут сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 87.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 122.6 сая төгрөг болж 35.0 сая төгрөгөөр буюу 40 хувиар өссөн байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 22.8 сая төгрөг нь Төрийн сангийн харилцах дансанд 30,8 сая төгрөг нь ОНХС-ийн дансанд, СХС-ийн дансанд 68.8 сая төгрөг байршиж байна.

#### 3.5.2 Авлага

Авлага Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. дансны эхний үлдэгдэл 229,3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 201,7 сая төгрөг болж 27,6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №02 Авлагын үлдэгдэл /мян.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	1,979.90	2,018.3	38.4
Байгууллагаас авах авлага		17,317.5	17,317.5
Зээлийн хүүгийн авлага	178,117.4	145,298.7	(32,818.7)
Тусгай зориулалтын сан	27,288.7	14,480.7	(12,808.0)
Дансны авлага /ОНӨААТҮГ/	21,987.0	21,861.0	(126.0)
<b>Дүн</b>	<b>229,373.0</b>	<b>200,976.2</b>	<b>(28,396.8)</b>

Эх сурвалж: Дуут сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 2.8 сая төгрөгийн дараах авлага байна.

Нийт авлагын дийлэнхийг сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага эзэлж байгаа бөгөөд оны эхэнд 178.1 сая төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байсан ба тайлант онд зээл олгоогүй, 32.9 сая төгрөгийн зээл, зээлийн хүү эргэн төлөгдөж, оны эцэст 145.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

ОНХС-гийн авлагад бүртгэлтэй малжуулахын авлагын эхний үлдэгдэл 27.2 сая төгрөгөөс тайлант онд 9.8 сая төгрөгийн авлагыг барагдуулж, шүүхийн шийдвэрээр 3.0 сая төгрөгийг хэрэгсэхгүй болгож, оны эцэст авлага 14.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### **3.5.3 Бараа материал**

Бараа материалын дансны үлдэгдэл 66.8 сая төгрөг, оны эцэст 68.8 сая төгрөг болж 2.0 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 211.1 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, хандив тусламжаар 39.9 сая төгрөг нийт 251.0 сая төгрөгөөр нэмэгдэж, 244.4 сая төгрөгийн материалыг зарцуулсан байна.

### **3.5.4 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 6850.0 сая төгрөг байсан бол оны эцэст 6909.4 сая төгрөг болж 198.2 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 13.4 сая төгрөг, хандив тусламжаар 98.2 сая төгрөг, 85.9 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж авсантай холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө 138.8 сая төгрөгөөр буурсан нь 46.3 сая төгрөгийн хөрөнгийг акталсан, 92.4 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн байна.

### **3.5.6 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ эхний үлдэгдэл 11.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4.3 сая төгрөг болж 6.9 сая төгрөгөөр буурсан байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд байгаа 4.3 сая төгрөгийн өр байгаа нь дараа тайлангийн хугацаанд бүрэн барагдах боломжтой өглөгүүд байна.

### **3.5.7 Цэвэр хөрөнгө, өмч**

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 6026.9 сая төгрөг байсан оны эцэст 5604.7 сая төгрөг тайлант онд 422.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 421.8 сая төгрөгийн алдагдалтай, нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтөөр 0.4 сая төгрөгийн өөрчлөлт орж өмнөх оны үр дүн дансанд өөрчлөлт орсон зэрэгтэй холбоотой байна.

## **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Дуут сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18 өдрийн 2/7 тоот тогтоолоор 1925.5 сая төгрөгөөр анх баталжээ. Цар тахалтай холбоотойгоор 2021 онд 1 удаа тодотгол хийн 2021 оны 8 сарын 27-ны 4/3 тоот тогтоолоор нийт 1919.8 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2125.4 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2125.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн тодотголыг сумын ИТХ-аар 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн Б/02 тоот тогтоолоор 1919,8 сая төгрөгөөр 6 байгууллага, 2 сангийн төсвийг тодотгож баталжээ.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1919.8 сая төгрөгийн төсөв баталснаас 1290.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 502.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, ОНХСангаас 81.0 сая төгрөг, сум хөгжүүлэх сангаар 45.0 сая төгрөг, 0.6 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Дуут сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 8 дүгээр сарын 27-ны өдрийн 2/07 дугаар тогтоолд Дуут сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 47.6 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 63.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 133.7 хувиар биелүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1166.4 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 0.1 сая төгрөг нийт 1166.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1152.4 сая төгрөгийг зарцуулж 14.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1843.3 сая төгрөг буюу 96.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 11.1 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 0.1 сая бараа хангамж, бараа материалын зардал 0.2 сая томилолтын зардал 1.8 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 4.0 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 3190.5 сая төгрөг буюу 199.1 хувиар давуулж биелүүлж орлогыг 3189.9 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Дуут сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2020 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 13/02 дугаар тогтоолд Дуут сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 45.6 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 62.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 136 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 3. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/Сая.төгрөг/

Орлогын ангилал	2021 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Татварын орлого	45.6	62.1	(16.5)
Орлогын албан татвар	8.0	23.2	(15.2)
Хувь хүний орлогын албан татвар	8.0	23.2	(15.2)
Үйл ажиллагааны орлого	1.0	14.0	(13.0)
Шууд бус орлого	7.0	9.2	(2.2)
Хөрөнгийн албан татвар	18.6	36.4	(17.8)
Бууны албан татвар	3.6	3.3	0.3
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	15.0	15.5	(0.5)
Малын хөлийн албан татвар	-	17.6	(17.6)
Бусад татвар, төлбөр, хураамж	18.1	1.6	16.5
Улсын тэмдэгтийн хураамж	0.9	0.7	0.2
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	0.2		0.2

Хог хаягдлын үйлчилгээний хураамж	0.7	0.5	0.2
Газрын төлбөр	0.3	0.3	-
Газрын төлбөр	0.3	0.3	-
Байгалийн нөөц ашигласны төлбөр	17.8	1.3	16.5
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	17.1	1.0	16.1
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.2		0.2
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	0.5	0.3	0.2
Татварын бус орлого	1.0	0.7	0.3
Нийтлэг татварын бус орлого	1.0	0.7	0.3
Торгуулийн орлого	1.0	0.7	0.3

Эх сурвалж: Дуут сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт орлого 62.1 сая төгрөгөөр буюу 16.5 төгрөгөөр давуулжээ. Орлого давсан шалтгаан нь хувь хүний орлогын албан татвар 15.2 сая төгрөг, хөрөнгийн албан татварын орлого 17.8 сая төгрөг, үйл ажиллагааны орлого 13.0 сая төгрөг, малын хөлийн албан татвар 17.6 сая төгрөгөөр давуулан биелүүлж ан амьтны нөөц ашигласны төлбөр 16.1 сая төгрөгөөр, хүү торгуулийн 0.3 сая төгрөгөөр, байгалийн нөөц ашигласны төлбөр 0.2 сая төгрөгөөр хог хаягдлын үйлчилгээний хураамж 0.2 сая төгрөгөөр тасалжээ. Татварын бус орлого тасрах үндсэн шалтгаан нь СХС-гийн орлогыг 38.3 сая төгрөгөөр тасалснаас шалтгаалжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 339.7 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 3.1 сая төгрөг нийт 339.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 324.5 сая мянган төгрөгийг зарцуулж 15.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 324.5 сая төгрөг буюу 95.5 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 10,6 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 0,1 сая, бараа хангамж, бараа материалын зардал 0,3 сая, томилолтын зардал 0,07 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 3.9 сая төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны давсан орлогын 0.1 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 3.1 сая төгрөг буюу 3.5 хувиар давуулж биелүүлж орлогыг 15.2 сая төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар ЭМДС-аас Ковид-19 цар тахлын илүү цаг урамшуулал, эмийн зардалд 98.8 сая төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 9.9 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 53.6 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 12.4 сая төгрөг, бусад орлогоос 3.4 сая төгрөг нийт 178.1 сая төгрөгийн орлого бүрдүүлэн 175.6 сая төгрөгийг зарцуулж орон нутгийн төсөвт 2.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дуут сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай дараах асуудлууд байна. Үүнд:

1. Сум хөгжүүлэх сангийн 2021 оны жилийн эцсийн 145.2 сая төгрөгийн зээлээс 13 иргэний 44.5 сая төгрөгийн зээлийн төлөх хугацаа болоогүй, 63 иргэний 100.7 сая төгрөгийн зээлийн авлага нь хугацаа хэтэрч байгаа нь сангийн хөрөнгийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.
2. “Эрдэст тайга” ХХК-тай 15 жилийн хугацаатай концессын гэрээ байгуулан сумын төсөвт байгууллагуудыг халаалт дулаанаар ханган ажиллаж тайлант онд өр үүсээгүй тайлагнасан ч төсөвт байгууллагуудад батлагдсан төсвөөр гэрээ байгуулан зардлыг санхүүжүүлсэн байна. Аудитын хугацаанд хэрэгжүүлсэн ажлын зураг төсөв, гэрээ, холбогдох материалыг аудитад ирүүлээгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Дуут сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд аймгийн ОНХО-аар 17.5 сая төгрөгийн гүний худгийн ажлын гүйцэтгэл, 9 иргэнд малжуулах төслөөс 14.4 сая төгрөгийн зээл олгосонтой холбоотой авлага үүссэн асуудлууд нь үлэмж нөлөө үзүүлсэн байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000 нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 119 хугацаандаа оруулсан, хугацаа хоцроосон мэдээлэлгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 2 гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил үйлчилгээний 3 гүйлгээ гарсныг тухай бүр шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй, түүнчлэн аудитын тайлан, дүгнэлт, бүтэн жилийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тоо мэдээлэл үзүүлэлтийн дэд дүн, нийт дүнг тусгаагүй, хэтрэлт хэмнэлтийн тайлбаргүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.4 сая төгрөгийн 1 төлбөрийн актыг бүрэн хэрэгжүүлж, 6.6 сая төгрөгийн 2 албан шаардлагын хэрэгжилт 50 хувьтай, 75.6 сая төгрөгийн 11 зөвлөмжийн хэрэгжилт 80 хувьтай хэрэгжүүлсэн байна.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар ОНХС-ийн хөрөнгө оруулалтын бодит гүйцэтгэл, Ковид-19 цар тахал, Шүлхий өвчинтэй холбоотой сумын төсөвт байгууллагуудаас гаргасан зардлын зарцуулалт, малжуулах төслөөс олгосон санхүүжилтийн асуудлыг авч үзэх нь зүйтэй байна.

## 2.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 5 тайланг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”-3(сумын 12 жилийн сургууль, сумын ЭМТ, сумын хүүхдийн цэцэрлэг) нийт 3 дүгнэлт гаргасан байна.

Дуут сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 18,3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, 8,0 сая төгрөгийн алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 10,3 сая төгрөгийн алдаа зөрчлөөс 10,3 сая төгрөгийн 7 алдаа зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Нийт алдаа зөрчил, шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дуут сумын 12 жилийн сургууль	2	2.9							2	2.9
2	Дуут сумын хүүхдийн цэцэрлэг	3	3.6	1	0.08					2	3.5
3	Дуут сумын ЭМТ	8	11.8	5	7.9					3	3.9
	<b>Дүн</b>	<b>13</b>	<b>18.3</b>	<b>6</b>	<b>8.0</b>	-	-	-	-	<b>7</b>	<b>10.3</b>

*Эх сурвалж: Дуут сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

## 4. Нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 503.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1.3 сая төгрөгийн алдааг залруулж, 8,4 сая төгрөгийн 5 алдаа зөрчилд төлбөрийн акт, 358.5 сая төгрөгийн 5 алдаа зөрчилд албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 135.0 сая төгрөгийн 10 зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Ажилчдад олгосон томилолтын урьдчилгааг авлагаар бүртгэсэн 1.3 сая төгрөг.
2. ОНХС-ийн өвсний тооцооны авлага бүртгээгүй 4.9 сая
3. Малжуулахын зээлийн 3.0 сая төгрөгийн авлагыг данс бүртгэлээс хассан зөрчил дутагдал илэрлээ.

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 9.2 сая төгрөгийн залруулга хийж, залруулсан 2022 оны 03 дугаар сарын 24-ны 8 тоот албан бичгээр санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.

## 4.2 Төлбөрийн акт

1.Тайлант онд төлөөлөгч хөтөлбөрийн санхүүжилтийг ИТХ -ын дарга Ц.Одбаатарын хувийн дансанд шилжүүлсэн. Уг хөтөлбөрийн хийгдэх ажлын төлөвлөгөө, хөтөлбөр байхгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, хийгдсэн ажлын хүрсэн үр дүн, үр ашгийг тооцоогүй зөрчил дутагдал илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7.-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн тэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** 1.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

## 4.2 Төлбөрийн акт

2. Дуут сумын ОНХС-аас 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтад батлагдсан төлөөлөгч хөтөлбөрийн 3.0 сая, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал 1.1 сая төгрөг нийт 4.1 сая төгрөгийн төсөл хөтөлбөр нь нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагааг төлөвлөж баталсан, хэрэгжүүлсэн зөрчил дутагдал илэрлээ. 2022 оны ОНХС-ийн төлөөлөгчийн хөтөлбөрт 5.0 сая төгрөгийг баталсан өмнөх оны СТА өгөгдсөн албан шаардлага биелүүлээгүй зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хууль 60 дугаар зүйлийн 60.3.6-д “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”, 60.3.4.-д “нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа; ОНХС -ийн үйл ажиллагааны журмын 4.3.2.-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;”, журмын 9.4, 9.5-д “заасан байгууллага дангаараа болон иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан ОНХС-ийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагыг тухайн шатны ИТХ-аар жил бүр хэлэлцүүлнэ” гэсэн тэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Өмнөх оны СТА өгөгдсөн албан шаардлага биелүүлээгүй тул 5.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

3.ЗДТГ нэмэлт дансаар аймгийн ЗДТГ-аас засаг даргын А/827 тоот захирамжаар ковид 19 цар тахалтай тэмцэх үйл ажиллагаатай холбоотой үүссэн өрийг барагдуулахаар санхүүгийн дэмжлэг 5.0 сая төгрөг олгосны 1.8 сая төгрөгийн зарцуулалтыг зориулалт бусаар зарцуулж сумын ЗДТГ-ын халаалтын зардалд зарцуулсан байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 16.5.5 -д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт хангаагдаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийг зориулалтын бусаар зарцуулсан 1.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

4.Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор айл өрхийн цэвэр бохир усны хөнгөлөлтөд 3.0 сая төгрөгийг сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан цэвэр ус түгээдэг хүнтэй гэрээ байгуулан сар бүр 261 айл өрхөд ундны ус түгээж холбогдох зардалд 2.7 сая төгрөгийн олгож 0.3 сая төгрөгийг зориулалтын бусаар зарцуулсан зөрчил дутагдал илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулах” гэсэн хуулийн заалт, аудитын “Үнэн зөв байдал”, “Иж бүрэн” байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** 0,3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

5. Албан томилолт, цалин, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж илүү тооцож олгосон нийт 320.3 мянган төгрөгийг илүү олгосон зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5. “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гаргахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1. “Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан хугацааг харгалзан түүний сүүлийн бүтэн ажилласан гурван сарын хөдөлмөрийн хөлснөөс дор дурдсан хувь хэмжээгээр бодож олгоно: 5-14 жил ажилсан бол 55 хувь” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** анхан шатны баримтын бүрдэлгүй 0,3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

### 4.3 Албан шаардлага

#### **Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлттэй холбоотой**

**1.Илрүүлэлт:** Дуут сумын ОНХС-аас 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтад батлагдсан шинээр эхлэх хөрөнгө оруулалт 3, их засвар 11, төсөл хөтөлбөр 4 нийт 18 төрлийн 81,0 сая төгрөгийн санхүүжилт бүхий бараа, ажил үйлчилгээ нь ажлын даалгаваргүй, зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдээгүй, бусад холбогдох зөвшөөрөл байхгүй төсөл арга хэмжээг төлөвлөж баталсан зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь ОНХС-ийн үйл ажиллагааны журам 3.1.3.-д ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх” гэсэнтэй нийцэхгүй байна.

**1.2 Шийдвэрлэсэн нь:** ОНХС-аас хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтад батлагдсан бараа, ажил үйлчилгээний ажлын даалгавар, зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн төсөл арга хэмжээг төлөвлөж батлах.

**ОНХС-ийн хөрөнгийг зарцуулахыг зөвшөөрөхгүй зардал төлөвлөсөнтэй холбоотой.**

**2.Илрүүлэлт:** Тайлант онд ОНХС-ийн төлөвлөлтөд гамшгаас хамгаалах сан гэж 7.0 сая төгрөг, 2022 оны ОНХС-ийн төлөвлөлтөд гамшгаас хамгаалах сан 10.0 сая төгрөг төлөвлөж байгаа нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51.4 -д “аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэснийг зөрчсөн байна.

Энэ нь Гамшгаас хамгаалах тухай хууль 51 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт 51.1.-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь жил бүрийн төсвийн багцдаа гамшигийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, зардлыг тусгана”. 51.4-д “Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах төвлөрсөн арга хэмжээний зардлыг улсын төсвөөс, аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд зардлаа өөрөө хариуцна”, 51.2-д “Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, нийслэл, сум, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцуулна. ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 11.2 -д. “ОНХС-ийн төсөв боловсруулах, батлах, зарцуулах, тайлагнах, бүртгэх, хяналт тавих, зохион байгуулахад хууль тогтоомж зөрчсөн бол тухайн байгууллага, албан

тушаалтанд Төсвийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.” гэсэнтэй нийцэхгүй байна

**2.1 Шийдвэрлэсэн нь:** ОХНС-ийн 2022 онд төлөвлөсөн хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхгүйгээр зогсоох албан шаардлага бичлээ. Албан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд албан тушаалтанд Төсвийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх саналыг ТЕЗ хүргүүлэх болно.

### **3.Ерөнхий чиглэлтэй холбоотой.**

**3.1 Илрүүлэлт:** ТТЗ-ийн харьяа төсвийн байгууллагууд нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй, төсөвт төвлөрүүлээгүй 122.3 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" нийцэхгүй байна

**3.2 Шийдвэрлэсэн нь:** Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах.

### **4.Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой.**

Шилэн дансны цахим системд оруулбал зохих мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлээгүй Үүнд:1. ТГТ зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дүн, хэтрэлт хэмнэлт, тайлбарыг дутуу мэдээлсэн 2. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний дүн дутуу мэдээлсэн 3. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг мэдээлээгүй 4. ТЕЗ-ын төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт мэдээлээгүй 5. Санхүүгийн тайлан /жилийн эцэс/ мэдээлээгүй байгаа шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн заалттай нийцэхгүй байна.

**3.2 Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.

### **5.Засгийн газрын тогтоолын хэрэгжилттэй холбоотой.**

**5.1 Илрүүлэлт:** Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна. Үүнд: 1. Ажиллагсдад урамшуулал, үр дүнгийн нэмэгдлүүд олгосон. 2. Хөрөнгө бэлтгэсэн 3. Тэвчиж болох зардал буюу хоол унаа, бусад арга хэмжээ, шагнал, спортын арга хэмжээ, бараа материал худалдан авсан, зэрэг тэвчиж болох зардлуудыг санхүүжүүлсэн, үйлчлэгч Д.Батбаярт сар бүр үндсэн цалингийн 10 хувийн нэмэгдлийг байгууллагын албан бичиг хүргэдэг гэсэн үндэслэлээр ямар ч тушаал шийдвэргүй олгож төсвийг үрэлгэн зарцуулсан зөрчил дутагдал илэрлээ.

Бүх шатны төсөв захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1. "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10- аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" 1.2. "Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаалтан бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх,өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх" гэсэнтэй нийцэхгүй байна.

**5.2 Шийдвэрлэсэн нь:** Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах.

## **6. Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагатай холбоотой.**

**6.1 Илрүүлэлт:** Сум хөгжүүлэх сангийн 2021 оны жилийн эцсийн 145.2 сая төгрөгийн зээлээс 63 иргэний 127.6 сая төгрөгийн зээлийн авлага нь хугацаа хэтэрч байгаа нь сангийн хөрөнгийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулсан, малжуулах төслийн 2013-2017 онд олгосон 9 иргэн холбоотой 17.4 сая төгрөгийн авлага төлөгдөөгүй нийт **145,0** сая төгрөгийг сангийн дансанд төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Сум хөгжүүлэх сангаас олгох барьцаат зээлийн гэрээний 2.1.4-д "авсан зээл, түүний хүүгийн төлбөрийг энэхүү гэрээний хавсралтад заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд зээлдэгчийн харилцах данснаас үл маргах журмаар мөн зохих журмын дагуу зээлийг төлүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээ авна", 3.4-д "энэхүү гэрээтэй холбогдсон аливаа маргаан асуудлыг 2 тал хамтран оролцож шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэх боломжгүй бол асуудлыг Монгол улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ", ОНХС-ийн хөрөнгөөр малжуулсан малчинтай хийх зээлийн гэрээний 2-д "Малжуулах зээлийг зээлдэгч зээл олгосон өдрөөс эхлэн 3 жилийн хугацаанд хүү тооцохгүйгээр хуваарийн дагуу бүрэн төлж дуусгана" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**6.2 Шийдвэрлэсэн нь:** Хавсралтад дурдсан зээлээ хугацаандаа төлөөгүй иргэдийг холбогдох хуульд заасны дагуу хууль хяналтын байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх

## **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1.ОНХС-ийн хөтөлбөр, арга хэмжээний зарцуулалттай холбоотой**

**1.1Илрүүлэлт:** ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй, хүлээж авах ажлын хэсгийн томилоогүй, хөтөлбөрийн хүрэх үр дүнг тооцдоггүй зөрчил дутагдал нийтлэг байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:** ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны "Журам шинэчлэн батлах тухай" 89 дүгээр тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд хийнэ гэсэн журмын хэрэгжилтийг ханган ажиллах.

### **2.Сум хөгжүүлэх сангийн авлагатай холбоотой**

**2.1Илрүүлэлт:** Тайлант оны сангийн хөрөнгийн орлого, зарлагын гүйцэтгэлийг нэгтгэн жилийн тайланд тусгасан байгаа ч сангийн хөрөнгийн тооцоог он бүрээр нь дэлгэрэнгүй хийдэггүй, зээл олгосон оноос хойш он, онуудаар нэгтгэсэн зээлийн эксэл файлын зээлийн эргэн төлөлтийн нийт орлого зөрүүтэй байгаа нь санхүүгийн тайланд сангийн авлагыг зөрүүтэй тусгасан байх магадлал өндөр байна

**2.2 Өгсөн зөвлөмж:** Сум хөгжүүлэх сангийн тооцооллыг дахин нягтлан тооцоог хийх шаардлагатай байгаад хугацаатай зөвлөмж өгөгдлөө.

### **3.Үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой асуудал**

**3.1.Илрүүлэлт:** Дуут сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 54.0 сая төгрөгийн үнэтэй квош тракторыг хувь хүнд ямар нэгэн гэрээ хэлцэлгүйгээр ашиглуулж байгаа зөрчил дутагдал илэрлээ.

**3.2Өгсөн зөвлөмж** Төсвийн тухай хуулийн 23.9.2-д “орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого,” хөрөнгийн ашиглалтыг сайжруулж, түрээсийн гэрээ байгуулах.

#### **4.Хөрөнгө оруулалтын үр дүнтэй холбоотой**

**4.1 Илрүүлэлт :** Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2020 оны хөрөнгө оруулалтаар суманд эрх шилжүүлэн 25.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий худгийн тендер зарлагдаж Алтайн улаан зоо ХХК шалгарсан боловч одоог хүртэл ажил эхлээгүй зөрчил дутагдал илэрлээ.

**4.2 Өгсөн зөвлөмж:** Тендерийн гэрээний хэрэгжилтийг ханган ажиллуулах.

#### **5.Батлагдсан орон тоотой холбоотой**

**5.1Илрүүлэлт:** Сумын Соёлын төв нь батлагдаагүй орон тоонд ажил хавсарсны нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.9-д " 16.5.9.дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох гэсэнтэй нийцэхгүй байна.

**5.2 Өгсөн зөвлөмж:** Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллуулах.

#### **6.Шатахууны зарцуулалттай холбоотой.**

**6.1Илрүүлэлт:** Ажилтан албан хаагчдын хувийн унаанд шатахуун олгож албан хэрэгцээнд зарцуулдаг болон Засаг даргын ХОА 77-43 дугаарын УАЗ ПАТРИОТ маркын авто машинд шатахуун олгосон нь явсан ажлын тайланг хавсаргаж оруулаагүй, жолоочийн тооцоог үнэн зөв бодож хянаагүй зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Нягтлан болох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" 20 дугаар зүйлийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх; гэсэнтэй нийцэхгүй байна.

**6.2 Өгөгдсөн зөвлөмж:** Жолоочийн тооцооны хуудсыг бодож хэвших, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.

#### **7. И баримт болон анхан шатны баримт дутуу ажил гүйлгээтэй холбоотой**

**7.1Илрүүлэлт:** И баримт болон анхан шатны баримт дутуу ажил гүйлгээг зарцуулахгүй байх

Энэ нь 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулах

**7.2 Өгсөн зөвлөмж:** Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ санхүүжүүлэхгүй байх.

### 8.Насжилт өндөртэй авлагатай холбоотой

**8.1Илрүүлэлт:** ЗДТГ-ын тайлан баланст он дамжсан насжилт өндөртэй авлагыг барагдуулаагүй 2.8 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5."Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэнтэй нийцэхгүй байна.

**8.2 Өгсөн зөвлөмж:** Өр, авлага үүсгэхгүй ажиллах зөвлөмж өгөгдлөө.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Сая. Төгрөгөөр

д/д	байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дуут ЗДТГ	11	121.3	1	1.3	3	2.40	2	31.50	5	86.1
2	Дуут ИТХ	-	-								
3	Дуут Соёлын төв	1	0.8							1	0.8
4	Дуут ОНХС	8	113.4			3	6.00	2	91.00	3	16.4
5	Дуут СХС	2	145.0					1	145.00	1	-
6	ТТЗ	1	122.5					1	122.50		
	<b>Дүн</b>	<b>22</b>	<b>503.0</b>	<b>1</b>	<b>1.3</b>	<b>6</b>	<b>8.40</b>	<b>5</b>	<b>390.00</b>	<b>10</b>	<b>103.3</b>

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН

АУДИТОР:

Д.БАЛЖИННЯМ